

## Хотын төв паркийн захиргаа

1961-6-24-нд Сайд нарын Зөвлөлийн 330 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төв паркийн захиргааг 1961-6-25-наас Улаанбаатар хотын захиргааны харьяанд байгуулахаар тогтоожээ.

1961-11-24-нд Сайд нарын Зөвлөлийн 601-р тогтоолоор Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны соёлын хэлтэс, хөдөлмөрийн товчоо, тээврийн хэлтсийг татан буулгаж мөн захиргааны зохион байгуулалтыг:

- Хотын төлөвлөгөөний комисс
- Эрүүлийг хамгаалах газар
- Санхүүгийн хэлтэс
- Гэгээрлийн хэлтэс
- Цэргийн хэлтэс
- Зохион зааварлах хэлтэс

Ерөнхий хэлтэс гэж баталсан.

1962 онд Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа хэмээх болсон.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс 1965 оны 04 сарын 14-ний өдөр гаргасан 79 дүгээр зарлигаар хороодыг татан буулгаж, Улаанбаатар хотод Сүхбаатар, Октябрь, Ажилчин, Найрамдал, гэсэн 4 районыг байгуулсан.

МАХН-ын Төв хороо улс төрийн товчооны 1965 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 333 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын хүүхэд, залуучуудын дунд улс төр, соёл, хүмүүжлийн ажлыг өргөнөөр зохион байгуулж, тэдний чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөх байх зорилгоор "Хот соёл амралтын парк" нэртэйгээр МХЗЭ-ийн төв хорооны харьяанд байгуулсан.

Паркийг 1966 онд нээгээд өргөтгөж бүтээн байгуулах ажил 1969 он хүртэл үргэлжилсэн.

Тус паркийг 1966 анх нээх үед 37га талбайд 6,0 мянган мод бут 60 гаруй мянган м2 зүлэгжсэн талбай 2,8 км зам МХЗЭ-ийн пионерийн талбай бага оврын морин тойруулга, дүрст тойруулга алсыг харагч микро поезд, гинжит тойруулга, пуужин, савлуур хүүхдийн машин, дугуй, угсаатны зүйн музей, үлгэрийн кино театр, тунгалаг уст жижиг нуур, завь алтанхүү баатар, хүч сорих мэргэн буудах тоглоом, хийн буудлага, теннис, биллирад фудбол зэрэг 27 нэр төрлийн цэг нэгж ашиглалтад орж нээгдсэн байна.

1987 онд БНХАУ-ын СнЗ-ийн тогоол гаргуулан "Туяа" кафег тус байгууллагын харьяанд авч хөдөлмөрчдийн Соёл амралтын үйлчилгээний иж бүрэн цогцолбор байгуулан "Туяа" кафег түшиглүүлэн "Чөлөөт цагийн дахь гариг" диско клуб байгуулан төрөл бүрийн шинэ хэлбэрийн ажил зохион явуудаг болсны дээр паркаа үндэсний парк болгон өөрчлөн тохижуулах зорилгоор 1986 оноос "Урлал чимэглэл"-ийн мастериин газар шинээр байгуулсан. Мөн хашааны баруун ба төв хаалга, ардын язгуур урлагийн "Түмэн Эх" чуулгын байр "Хотол баясгалант" харш гадаадын аялагч жуулчдыг хүлээн авч үйлчлэх

өрөө дэлгүүр монгол үндэсний иж бүрэн тоног төхөөрөмжтэй сийлбэр, гоёл чимэглэлтэй гэр, цэцгийн хүлэмж автомат тоглоомын төвийг шинээр барьж байгуулсан.

1991 оноос "Монголын Үндэсний Соёл амралтын хүрээлэн " гэдэг болсон.